

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Эмэгтэйчүүдийн өртөж буй хүчирхийллийн эсрэг залбирал

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар дэлхий даяар гурван эмэгтэй тутмын нэг нь амьдралынхаа түүрхэнд бие махбодийн, сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийлэлд өртдөг гэж үзжээ. Гэр бүлийн хүчирхийлэл хамгийн өндөр хувь эзэлдэг бөгөөд цахим хүчирхийлэл болон хүчээр гэрлүүлэх явдал зэрэг нь өнөөдрийг хүртэл ноцтой асуудлууд хэвээр байна. Зөвхөн Африк тивд л гэхэд 230 гаруй сая охид, эмэгтэйчүүд эмэгтэйчүүд бэлэг эрхтний гэмтэл (FGM)-д өртөж байсан байна. Эзэн минь, бид шархалсан зүрх, ядарсан сэтгэлээ Таны өмнө тавьж байна. Таны амар амгалан, шинэчилсэн хүч, найдвар бидний дээр ирж, сэтгэлийг минь тэтгэж, биднийг зооноосон хүмүүсийг хүртэл уучлах чадал өгөх болтугай. Та Биднийг бүтээсэн Эзэн, бидний хайртай хүүхдүүд гэдгийг өдөр бүр сануулж, биднийг Өөрийн амралт руу урих болтугай.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

4. Хятад улсад бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын олон тохиолдол мэдээллээс гадуур байна. Эзэн минь хохирогчдын аюулгүй байдлыг хангаж, эдгээж, сэргээгээч. (Дуулал 10:17-18)

5. Аав аа, хойд Кипрт худал амлалтанд хууртагдаж, паспортоо хураалгаж, болон сэтгэлийн боолчлолд орсон олон эмэгтэйчүүдийг бие ба сэтгэлээр нь чөлөөлөх болтугай. (Исаиа 61:1)

6. Бурхан минь, Дани улсад гэр бүлийн хүчирхийлэл, биеэ үнэлэх, порно бүтээх салбарын боолчлолд өртөж буй эмэгтэйчүүдийг Та авраач. (2 Самуел 22:2-3)

7. Аав аа, Финляндын өнцөг булан бүрт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ээж, хүүхдүүдэд зориулсан орон байр байгаад талархаж байна. Тэдний амьдралд эдгэрэлийг авчраач. (Дуулал 139:5)

8. Францад гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол 2016 оноос хоёр дахин нэмэгсэн байна. Эзэн минь, эрчүүд таны үгийг дагаж, эхнэрээ хайрлаж, хатуу хандахаас хамгаалаач. (Колоссо 3:19)

9. Эзэн минь, Индонезид түншүүдийнхээ нөлөөгөөр ДОХ-той болсон эмэгтэйчүүдийг эдгээж, олон хүүхдүүд халдвар авахаас Та хамгаалаач (Дуулал 30:2)

10. Бурхан минь, Японд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг авраач. Тэд Христийг аврагч гэж мэдэж, түүний хайрыг ойлгож, эдгэрэх болтугай. (Дуулал 103:6-8)

11. Аав аа, Либерида үрчлэл, incest-ийн асуудлыг шийдэх сүмийн удирдагчдыг Та босгож, айдас ба ичгүүрийн улмаас дотроо зовж буй эмэгтэйчүүд, охидыг эдгээх болтугай. (Езекел 22:11)

12. Эзэн минь, Малайзад эмэгтэйчүүдийн бэлгийн эрхтнийг зэрэмдэглэдэг хортой зан үйлийг зүгсөөж, тэдний шархыг эдгээж, сэтгэлийг нь тайвшруулаач. Удирдагчдын зүрхийг хөдөлгөн энэ зан үйлийг зогсоох хууль гаргах болтугай. (Исаиа 1:17)

13. Хүүхдийн эрт гэрлэлт, хоригдсон эмэгтэйчүүд, зах хязгаарлагдмал нөхцөлд амьдардаг хүмүүс Христ дээр ирж, үнэхээр өөрийн үнэ цэнээ мэдэх болтугай. (Галат 5:1)

14. Монгол эмэгтэйчүүдийн 40% нь сэтгэл зүйн болон эдийн засгийн хүчирхийлэлд өртдөг. Эцэг минь, эдгээж, аюулгүй байдлыг бий болгож өгөөч. (Иеремиа 22:16)

15. Нигери улсад бэлгийн хүчирхийлэл, хүчээр гэрлүүлэх, бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд амар амгаланг өгч, гэмт этгээдүүдийг шийтгэх болтугай. (Дуулал 32:7)

16. Хойд Африкийн Христэч эмэгтэйчүүд ихэвчлэн мөлжлөг, үг тоогдох байдалд өртдөг. Таны Сүнс тэдэнд найдвар өгч, Христэд бат зогсох чадварыг олох болтугай. (Үйлс 14:22)

17. Папуа Шинэ Гвинейд эмэгтэйчүүдийг бэлгийн үнэтэй гэж уламжлалт соёлоор доромжилдог. Эзэн минь, шархыг нь эдгээж, сүнсийг нь босгооч. (Иеремиа 22:3)

18. Филиппинд хүчирхийлэл нэмэгдэж, охидын цэвэр ариун байдал алдагдаж байна. Тэдний амьдралыг эдгээж, хамгаалж, сэргээгээч. (Иеремиа 33:6)

19. Португалд эмэгтэйчүүдэд үзүүлж буй хүчирхийлэл, үг хэлний доромжлол нэмэгдэж байна. Эзэн минь, эмэгтэйчүүдийг хамгаалах хууль батлагдаж, залуу эрчүүдэд эмэгтэйчүүдийг хүндэтгэх сэтгэлийг өгөөч. (Матай 22:39)

20. Өмнөд Африкын төрийн удирдагчдад хүүхэд ба эмэгтэйчүүдийн хүчирхийллийн асуудлыг шийдэх мэргэн ухааныг өгөөч. (1 Тим. 2:1-2)

21. Солонгост болзооныхоо үеэр хүчирхийлэлд өртөж нас барах тохиолдол 3-4 хоногт нэг удаа гардаг. Эзэн минь, хайр гэж ойлгодоггүй хүчирхийллээс охид эмэгтэйчүүдийг хамгаалаач. (Ефес 4:31-32)

22. Танзанид эмэгтэйчүүд уламжлалт зан үйлийн улмаас, бэлэг эрхтний гэмтэл, бие махбодийн шийтгэлд өртдөг. Соёлын өөрчлөлтийг Та авчраач. (Галат 5:14)

23. Тимор-Лестед гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд эдийн засгийн болон нийгмийн шалтгаанаар хэлэхээс айдаг. Тэдний дотор байгаа чимээгүй зовлонд гэрэл тусгаач хэмээн залбирч байна. (Сургаалт 31:8-9)

24. Уругвайн эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамгаалаач. Хүчирхийлэл үйлдэж буй этгээдийн зүрхийг өөрчлөх болтугай. (Сургаалт 18:10)

25. Вьетнамын эмэгтэйчүүдийг сэтгэл санааны болон сүнслэг боолчлолоос эдгээж, зүрх сэтгэлийг нь өргөж, Таны хайр дотор чөлөөлөгдөх болтугай. (Исаиа 40:29-31)

26. Эзэн минь, Zanzibar-д шинэ TWR Women of Hope гэмтлийн эдгээх сургалтанд хамрагдсан 28 эмэгтэйн дотоод шархыг Та эдгээгээч. (Дуулал 34:18)

27. Камбожд охидыг бага наснаас нь гэрлүүлэхийг эцэг эх нь хүчээр шахдаг соёлыг Та өөрчлөх болтугай. (Ром 13:10)

28. Дундад дорнодод итгэлээсээ болж хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд амар амгаланг Та өгөх болтугай. (Ром 8:31)

29. Хойд Нигери улсад эмэгтэйчүүдийг мөлжиж, хүчирхийллийг дэмждэг соёл, итгэл үнэмшлийг Та өөрчлөөч. (Галат 3:28)

30. Эмэгтэйчүүдийн 20% нь насан туршдаа ойр дотны хүнээс хүчирхийлэлд өртөж байна. Олон эмэгтэйчүүд эдгээрийг мэдээлж, буруутай этгээдийг илчлэх болтугай. (Дуулал 51:10)

31. Нэгдсэн Үндэстний Байгууллагын сүүлийн тайланд дэлхий даяар эмэгтэйчүүд 10 минут тутамд нас бардаг гэжээ. Олон эмэгтэйчүүд итгэлээ Танд тавьж аврагдах болтугай. (Дуулал 46:1)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Малчид өвөл болж хүйтрэхээс өмнө өвлийн бэлтгэлээ хийж бэлтгэлтэй байхын тулд Бурхан минь Та тэднийг хангаач төлөө.
2. Баянхонгорт шинээр эхэлсэн эмэгтэйчүүдийн залбирлын бүлгийн төлөө. Тэд тогтмол цуглаж, өсөж хөгжихөд нь Бурхан туслахын төлөө, уг бүлгийг удирдаж, чиглүүлж буй Сүүгий эгчид Бурхан мэргэн ухаан, сүнслэг ялган таних чадвар өгөхийн төлөө.
3. Ховдын залбирлын бүлгийн удирдагч Золоог Бурхан бүрэн эдгээж, хүч чадал өгч, удахгүй өвдөлтгүй алхахын төлөө.

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.